

СОЁЛЫГ АРТЕФАКТТАЙ АНДУУРАХ НЬ

Т.Дорждагва Б.Гантөмөр - МУИС, НЦУС. Философийн тэнхим

Түлхүүр үг: Соёл, материаллаг соёл, материаллаг бус соёл, артефакт, хоёрдогч байгаль, соёлын эд өлгийн зүйлс.

Өнөөгийн ертөнцөд соёлын тухай асуудал сургалт, судалгааны төдийгүй практик хэрэглээ, ахуй амьдралын хамгийн тулгамдсан асуудлын нэг яах аргагүй болсон байна. Соёл бол нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарч, түүний булан тохой болгоныг тэмтэрч байдаг нь үнэн л дээ. Тэгэхлээр соёлын тухай толгойтой бүхэн эргэцүүлж, амтай болгон дугарч, боломжтой зарим нь бичих болж. Болж байна. Бид бүгдээрээ л үнэнийг хайж байгаа шүү дээ.

Соёлын тухай асуудал мэдлэгийн олон салбарт хамааралтай ч түүнийг ялангуяа хүмүүнлэгийн шинжлэх ухааны хүрээнд илүүтэй сонирхон судалдаг нь хэн оүхэнд ойлгомжтой биз ээ. Гэхдээ энэ асуудлыг нухацтай авч үзье гэвэл философийн хөгжлийн буурал түүхийг сөхөхөөс аргагүйд хүрэх болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм. Гэтэл философи нь уг чанараараа үнэлэмжийн шинжтэй байдаг учраас үе үеийн сэтгэгчид өөр өөрийн онцлогтой философи чиглэлийн байр сууринаас уг асуудлыг боловсруулж ирсэн нь илэрхий байдаг.

АНУ-ын соёлын хүн судлаач А.Кребер, К.Клакхон нар “Culture. A Critical Review of Definitions and Concepts” нэртэй номоо 1952 онд Кембридж-Массачусетс хотноо хэвлүүлж, түүндээ Английн угсаатны зүйч Эдуард Бернетт Тайлор соёлын тухай анхны тодорхойлолтыг 1871 онд өгсөн гэдэг мэдээллийг тэмдэглэжээ. Мөн тэрчлэн эрдэмтэн судлаачид 1919 он гэхэд соёлын тухай 19, 1950 он гэхэд 157 тодорхойлолтыг томъёолсон гэдэг баримтыг энд бичсэн байна /2. 17/. Орчин үед мэдлэгийн олон салбар соёлыг тал бүрээс нь эрчимтэй судлах болсноор түүний тухай тодорхойлолтын тоо эдүгээ хагас мянга /3. 12; 4. 355/-аас давжээ. Дээр дурдсанчлан энэхүү олон тодорхойлолт нь судлаач, сэтгэгчдийн баримтлан мөрддөг онол, үзэл суртал, тэдний зорилго, арга барил, ашиг сонирхол зэргээс үүдэн бүр эсрэг тэсрэг байх нь ч бий. Харин гагцхүү соёлыг хүнтэй л холбогдуулан авч үздэг нь нийтлэг бөгөөд сайшаалтай байдаг юм. Соёл бол гагцхүү хүнтэй л холбоотой бөгөөд хүмүүнгүйгээр соёлыг, соёлгүйгээр хүмүүний тухай төсөөлөхийн аргагүй юм. Иймээс бидний үзэж байгаагаар бол “Соёл нь субъектээс ертөнцөд хандах, түүнийг өөрчлөн хувиргах, түүний дотор оршин байх хүмүүнлэг чадвар болно” /1. 315/.

Өөрөөр хэлбэл соёл нь хүмүүний төлөөнөө гэсэн тэдний оюуны болоод материаллаг үйл ажиллагааны чадвар билээ. Энэхүү тодорхойлолтыг томъёолохдоо соёлыг юуны түрүүнд субъектийн чадвар, өөрөөр хэлбэл түүний үйл ажиллагаа зорилгодоо хүрч чадах чадавхийн асуудалтай холбож өгөхийг эрмэлзсэн юм. Хүмүүнлэг чадварын ачаар хүн өөрөө адуусан амьтан болоод ертөнцийн бусад бүрдлээс ялгагдах бөгөөд хүмүүнлэг чадварын түвшин хэдий чинээ өндөр байна тухайн субъект (хувь хүн, гэр бүл, хамт олон, нийгмийн бүлгүүд, үндэстэн, ард түмнүүд болон нийт хүн төрөлхтөн)-ийн соёлын түвшин төдий чинээ өндөр байх юм. Гэхдээ субъект бүр өөрийн соёлын өвөрмөц онцлогтой байж, тэр нь ижил тэгш эрхтэй байх тухай үзэл санаа өнөөгийн ардчилсан ертөнцөд нэгэнт бодит байдал болсон билээ.

Гэтэл соёл хэмээх энэ үзэгдлийн талаар ердийн ухамсрын түвшинд төдийгүй албан баримт, эрх зүйн акт, түүгээр барахгүй судалгааны материал, сурах бичиг, гарын авлагад күртэл андуу ойлголтыг хэрэглээд зуршчихсан байгаа байдал ажиглагдаж байна. Бид энэ өгүүлэлдээ хоёрдогч байгаль болох материаллаг эд юмс бол соёл биш гэж шулуухан хэлэх гэсэн юм. Харин эдгээр нь хүний зорилго чиглэлтэй үйл ажиллагааны бүтээгдэхүүн болно. Ялангуяа артефактыг соёл гэж андуурах нь энүүхэнд. Артефакт гэдэг нь хүний гараар бүтээгдсэн аливаа материаллаг эд юмс, тухайлбал уран барилга, уурын машин, ном, сүм дуган, хөдөлмөрийн багаж зэвсэг, орон байр, сав суулга, хувцас, гоёл чимэглэлийн зүйлс, далан, суваг шуудуу гэх мэтчилэн бодитой оршин байх физик объектууд юм.

Бидний бодож байгаагаар соёлыг материаллаг ба материаллаг бус гэж ялган үзэж болох боловч хүний гараар бүтээгдсэн аливаа материаллаг эд юмс бол материаллаг соёл, хүний оюуны бүтээл бол материаллаг бус соёл гэж үзэх нь учир дутагдалтай мэт санагдана. Материаллаг эд юмс бол тухайн субъектийн соёлыг илэрхийлэн харуулагч, түүний материаллаг үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүн болохоос хүний хүмүүнлэг нэдвар нь өөрөө биш баймаар. Харин тэдгээрийг бүтээсэн субъектийн авьяас, ур чадварыг материаллаг соёл гэж нэрлэж болно. Андуу үнэлэмж, дарамттай хэм хэмжээ, хууль, дүрэм, утгагүй бэлгэдэл, төөрсөн мэдлэг, итгэл үнэмшил, чин эрмэлзлэл, гээвэл зохилтой заншил, хэвшил зуршил, мухар сүсэг бишрэл, харгис бурангуй үзэл санаа, сүтгэгч бодлого, оюуны хэрэгцээг хангахгүй урлаг зэрэг нь хэнд хэрэгтэй юм бэ? Эдгээр нь хүмүүнлэг юм гэж үү дээ? Үгүй л болов уу. Харин үнэлэмж, хэм хэмжээ, чин эрмэлзлэл, ёслол, шидэт домог, бэлгэдэл, заншил, уламжлал, хэвшил зуршил, баяр ёслол, ёслолын дэг, хууль цааз, дүрэм курам, үлгэр загвар, эталон, арга барил, мэдлэг, үзэл санаа, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, урлаг, хэл зэргийг буй болгосон субъектийн хүмүүнлэг чадварыг материаллаг бус соёл гэж нэрлэж болно.

Ишлэл авсан бүтээлүүд

1. Т.Дорждагва. Соёл судлалын бүтээлийн эмхэтгэл. -УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2005. - 358 тал. (45 х.х.)
2. Kroeber A.L., Kluchohn C. Culture. A Critical Review of Concepts and Definisions. -Cambridge-Massachusetts, 1952
3. Полищук В.И. Мировая и отечественная культура. -Екатеринбург, 1993.-Ч.1.
4. Хоруженко К.М. Культурология.Энциклопедический словарь.-Ростов-на-Дону: Изд-во"Феникс",1997. -640с.